



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 115

Номгон

“Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол” аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 29 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын  
29-ний өдрийн 145 дугаар тогтоолын хавсралт



## “БАЯНХОНГОРЧУУД БИДНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Эрүүл мэндийн талаар дэлхий нийтэд баримталж буй бодлого, үйл ажиллагаа нь дан ганц өвчнийг эмчлэхэд бус хүн амд эрүүл мэндийн боловсрол эзэмшигж, эрүүл зан үйлийг хэвшүүлэн төлөвшүүлэх, амьдарч, сурч, ажиллаж буй орчиндоо эрүүл мэндэд таатай нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлэхэд нь ард иргэдэд туслах, түүнд харилцан бие биенээ дэмждэг төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон иргэдийн хамтын ажиллагааг чиглүүлэх замаар хүн амын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэхэд чиглэгдэж байна.

Өнгөрсөн хугацаанд манай улсад эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр олон ажил хийгдэж тодорхой үр дүнд хүрсэн ч сургуулийн хичээлийн стандарт, ерөнхий хөтөлбөрт эрүүл мэндийн боловсрол, амьдралын арга ухаанд суралцах хичээл суугдаагүй, хавсарга хэлбэрээр явж ирсэн. Хэдий чинээ бага нааснаас нь эрүүл мэндийн боловсрол олгож, зөв мэдээллээр хангаж, амьдралын зөв хэв маягт оруулна төдий чинээ чанартай амьдралын эхлэлийг эрт тавьж өгөх юм. Эрүүл мэндийн боловсрол нь эрүүл мэндийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх болон хувь хүний, олон нийтийн эрүүл мэндэд ач тустай, амьдрах ур чадварыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, мэдээлэл харилцааны зарим хэлбэрт тулгуурласан, суралцах боломжийг олгох үйл ажиллагаа юм.

Аймаг нийт 85332 хүн амтай, хүн амын 31.5 хувийг 0-15 насны хүүхэд, 30.2 хувийг төрөх насны эмэгтэйчүүд, 49.3 хувийг эрэгтэйчүүд эзэлж, хөгжлийн бэрхшээлтэй 4562 иргэн байна. Хүн амын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт болох нийт төрөлт 2006-2009 онуудад өмнөх жилүүдээс нэмэгдэх хандлагатай байсан бол 2014 оноос буурч, эхийн эндэгдэл тогтвортой буурахгүй байна. Эндсэн эхчүүд нь ажилгүй, малчин, гэрлээгүй, хамтран амьдрагчтай зэрэг гэр бүлийн тогтвортгүй байдалтай байгаа нь анхаарал татаж байна. Нийт төрөлтөд эзлэх өсвөр насны охидын төрөлт буурахгүй улс, аймгийн дундажаас өндөр үзүүлэлттэй байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхдэд 30.0 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэмэгдэж, 1-5 насны хүүхдийн эндэгдлийн

50 хувийг осол гэмтлийн шалтгаант нас баралт эзэлж байна. Осол гэмтлийн шалтгааны улмаас 2016 онд 465 хүн эмнэлэгт хэвтэсний 16 хүртэлх насны хүүхэд 22.5 хувийг эзэлж байна. Хэвтэж эмчлүүлсэн 5 хүртэлх насны 67 хүүхдийн 65.6 хувь нь түлэгдэлтийн улмаас эмчлүүлжээ.

Хүн амын шилжилт, хөдөлгөөнтэй холбоотой бага насны хүүхэд өрх, сумын эмнэлгийн хяналтаас завсардах, жирэмсэн эмэгтэйчүүд эрт үедээ хяналтад орохгүй, эсвэл огт хяналтгүй байх, жирэмсэн эхчүүдийн дунд БЗДХ өндөр, биеийн байдал хүндэрсэн үедээ эмнэлэгт хандаж, тусlamж үйлчилгээ оройтох, жирэмсэн эх болон бага насны хүүхдийн хоол тэжээлийн дутал, суурь өвчинүүд, амьдралын түвшин доогуур өрхийн гишүүд эмчийн бичсэн эмийг авч чадахгүй өвчинеэ хүндрүүлэх, ахуйн осол гэмтэлүүд нь эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааныг цусны эргэлтийн тогтолцооны эмгэг, хорт хавдар, осол гэмтлийн шалтгаант нас баралт эзэлж, 51.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгааг эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.4 дахин их байна. Шинээр оношлогдсон хорт хавдрын эмчилгээ хийх боломжгүй үе шатандаа эмнэлэгт хандсанаар сүүлийн жилүүдэд хорт хавдрын нас баралт нэмэгдэн нийт хүн амын нас баралтын 2 дахь шалтгаан болж байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралт хүн амын нас баралтын 3 дахь шалтгаан болж, осол гэмтэлд өртөгсөдийн 80 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Зан үйлээс шалтгаалсан зүрх судасны өвчин, хорт хавдар, осол гэмтлийн өвчлөл, нас баралтын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байна. Осол гэмтлийн улмаас нас барах явдал эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 3.6 дахин их байгаагаас гадна амиа хорлолт эмэгтэйчүүдээс 7.3 дахин, зам тээврийн шалтгаант нас баралт 5 дахин өндөр байна. Осол гэмтэлд өртөн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн болон нас барсан эрэгтэйчүүдийн насны байдлыг авч үзэхэд 20-44 насны ид хөдөлмөрийн насныхан хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Хүн амын дунд амьсгалын тогтолцооны өвчин, хоол шингээх эрхтэний өвчин, зүрх судасны тогтолцооны өвчин, бөөр шээсний замын өвчин, хавдрын өвчний тархалт өндөр байгаа бөгөөд сүүлийн 2 жил амьсгалын тогтолцооны өвчин хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж байна. Зонхилон тохиолдож байгаа өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг бууруулах зорилгоор халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулснаар үзлэгийн хамрагдалт нэмэгдэж байгаа ч орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон ТББ, аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчдыг өргөнөөр татан оролцуулах, тэдний санал, санаачилгатайгаар үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн статистик мэдээллээр 2016 онд 21 төрлийн 2256 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10.000 хүн амд 270.7 байгааг 2015 онтой (178.3) харьцуулахад 1.5 дахин нэмэгдэж, улаанбурхан, энтеровирус, гахайн хавдар, трихоминиаз, хачигт риккетсиоз, бруцеллөз зэрэг халдварт өвчний тохиолдол нэмэгдсэн байна. Бэлгийн замаар дамжих халвар нийт халдварт өвчний 40.2 хувийг эзэлж, өвчлөгсдийн 71.8 хувийг 19-35 насынхан, 30.7 хувийг ажилгүй, 28.1 хувийг малчин, 9.4 хувийг оюутан, 85.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийт халдварт өвчний 43.7 хувийг улаан бурханы өвчлөл эзэлж, уушигны хатгаагаар хүндэрсэн улаан бурханы 10, сүрьеэгийн 2 нас баралт бүртгэгдсэн байна. Сүрьеэгийн өвчлөл улс, аймгийн дундажтай харьцуулахад бага байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд нас баралт буурахгүй, эмэнд дасалтай сүрьеэгийн өвчлөл нэмэгдэх хандлагатай байгаа нь сүрьеэ өвчний илрүүлэлт, эмчилгээний үр дүнд тавих хяналтыг сайжруулж, иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Халдварт бус өвчинүүдийн 60-70 хувь нь хөдөлгөөний хомсдол, буруу хооллолт, архи, тамхинд донтох зэрэг амьдралын буруу дадал хэвшлээс шалтгаалан үүсдэг бөгөөд иргэд эрүүл мэндийн боловсролтой болсноор эдгээр өвчинеэс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Эрүүл мэнд бол хүн хөдөлмөрийн өндөр бүтээмж гаргах чадвартай, амьдрал нь хүрэлцээтэй, сэтгэл санааны амгалан тайван, сайн сайхан байхын чухал хэрэгцээ юм. Олон улсын түвшинд хийсэн судалгаагаар хүний эрүүл мэндийг нөхцөлдүүлдэг хүчин зүйлд гадаад орчны хүчин зүйлс 20-25 хувь, удамшлын буюу дотоод хүчин зүйлс 50-55 хувь, эмнэлгээс шалтгаалах хүчин зүйлс 20-25 хувь тус тус эзэлдэг. Аливаа өвчинеэс урьдчилан сэргийлж болох хүчин зүйл нь 75 хувийг эзэлж байгаа нь иргэн хүний гарг өөрсдийгээ эрүүл байлгах боломж байгаа учраас тэдний хэрэгцээг хангасан эрүүл мэндийн боловсрол зайлшгүй шаардлагатай байгаатай уялдуулан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг үндэслэн энэхүү дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

#### Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1 Хөтөлбөрийн зорилго: Иргэн бүрт нас биений онцлогт тохирсон эрүүл мэндийн зөв мэдлэгийг олгох замаар эрүүл мэндийг дэмжигч таатай орчин бүрдүүлж, хүн амын эрүүл зан үйлийн мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэхэд оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилтууд: Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

3.2.1. Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйлийн хандлагыг төлөвшүүлэх

3.2.2. Θсвөр үе, залуучуудад чиглэсэн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, эрүүл мэндийн боловсрол олгох

3.2.3. Төрөх насны эмэгтэйчүүд болон жирэмсэн эхэд эрүүл мэндийн боловсрол олгох замаар эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах

3.2.4. Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх

3.2.5. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох

3.2.6. Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх

3.2.7. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох замаар хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх

**Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

4.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдүгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.1.1. Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулиудад эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх ээлтэй орчин бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын материал, хэрэглэгдэхүүнээр хангах

4.1.2. Сургуулиудад эрүүл мэндийн кабинет, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх өрөөг байгуулах

4.1.3. Эцэг эх, гэр булийн гишүүдийн оролцоог идэвхжүүлэх, тэдний сайн дурын хамтын ажиллагааг сайжруулах замаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын арга хэлбэрийг сонгон, сургалт сурталчилгааг тасралтгүй зохион байгуулах

4.1.4. Цэцэрлэгүүдэд эрүүл мэндийн ажилтан, арга зүйч нарыг бэлтгэж, чадавхжуулах

4.1.5. Сургуулийн эмч нарыг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургаж, чадавхжуулах

4.1.6. Сургууль, цэцэрлэгийн багш суралцагч нарт зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох гарын авлага, бусад хэрэглэгдхүүнийг боловсруулах, хэвлэх, түгээх

4.1.7 Цэцэрлэг, сургуулийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах

4.1.8 Эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэг болох хөдөлгөөн өрнүүлэх

4.1.9 Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг орон тоогоор ажиллуулах

4.1.10 Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг сургалт сурталчилгаа явуулах техник хэрэгслээр хангах

Хүрэх үр дүн: Насан туршийн амьдралдаа эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болон төлөвшиж, бие бялдрын хувьд эрүүл, чийрэг өсөх боломж бүрдэнэ.

4.2 Хөтөлбөрийн вийл ажиллагааны хоёрдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2.1 Ирээдүйн босго төв, Сайн дурын зөвлөгөө өгөх газрын үйл ажиллагаа өргөжүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн бус байгууллагатай хамтран өсвөр үе, залуучууд, залуу гэр бүлд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, бэлгийн замаар дамжих халдварт, ДОХ, ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх тухай мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт, өдөрлөг, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах

4.2.2 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдлэг мэдээлэл олгох нэвтрүүлгийг олон нийтийн сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх

4.2.3 Нөхөн үржихүйн талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэж, эцэг эхчүүд хүүхэдтэйгээ нээлттэй ярилцах боломж бүрдүүлэх

4.2.4 Өсвөр үе, залуучуудын дундах хорт зуршлын хэрэгцээг бууруулах, хорт зуршил, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, эрүүл зохистой хооллолтыг дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сургууль, гэр бүл, байгууллага хамт олны хүрээнд зохион байгуулах

4.2.5 Насан туршийн боловсрол хөтөлбөрт хамрагдаж байгаа залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг сургалтын төлөвлөгөө, цагтай уялдуулан хэрэгжүүлэх

4.2.6 Өсвөр үе, залуучууд, ахмад үеийнхний залгамж холбоог бэхжүүлэх санал санаачилгыг хөхүүлэн дэмжих

Хүрэх үр дүн: Амьдралын болон эрүүл мэндийн эрүүл зан үйлийн зөв мэдлэг, хандлагыг өсвөр үе, залуучуудад төлөвшүүлснээр эрүүл, боловсролтой иргэн болж төлөвшинэ.

4.3 Хөтөлбөрийн вийл ажиллагааны гуравдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ

4.3.1 Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрхийг шалгаруулах, сайн санааны болон хүрч очих ажилтанг бэлтгэх, чадавхжуулах, урамшуулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж, гэр бүл, хамт олны оролцоон дээр тулгуурлан нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, мэдлэг олгох ажлыг зохион байгуулах

4.3.2 Зорилтот бүлэгт чиглэсэн гэр бүл төлөвлөлт, эсэн мэнд амаржихуй, эмийн зохистой хэрэглээ, хүүхдийн асаргаа, сувилгаа, амны хөндийн эрүүл мэнд, хатгаа, суулгалт, БЗДХ, осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх асуудлаар зан үйлийг өөрчлөх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах

4.3.3 Хүүхдийг эрүүл өсгөх, асрах, сувилах, өвчинөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчдад сургалт, сурталчилгаа зохион байгуулах

4.3.4 Цэвэршилтийн насны хүн амд нөхөн үржихүйн дараах тусlamж үйчилгээний талаар мэдээлэл, сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг тэдний хэрэгцээнд тулгуурлан зохион байгуулах

4.3.5 Сумын нийгмийн ажилтан, багийн дарга, бага эмчийн оролцоотой өвөлжөөний болон зуслангийн явуулын сургалтыг зохион байгуулах

4.3.6 Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн эрхийг хамгаалах байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах

4.3.7 Жирэмсний хяналдад эрт орохын ач холбогдол, жирэмсэн үеийн дэглэм, аюултай шинж тэмдэгийн талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах

Хүрэх үр дүн: Нөхөн үржихүйн насны хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих асуудалд иргэн болон гэр бүлийн оролцоо, үүрэг хариуцлага нэмэгдэнэ.

4.4 Хөтөлбөрийн үйл ажиллагааны дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.4.1 Эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн ээлтэй тусlamж үйчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетыг байгуулах

4.4.2 Бүх шатны бодлого боловсруулагчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд өөрсдөд нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлын чухалыг сурталчилах, ойлгуулах нөлөөллийн ажлыг зохион байгуулах, оролцоог нэмэгдүүлэх

4.4.3 Байгууллага, хамт олон, гэр бүлд жендерийн эрх тэгш байдлыг хангасан эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэх

4.4.4 Эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн хамтлаг, клуб, багийн үйл ажиллагааг өргөжүүлэх замаар эрүүл зан үйлийг /осол гэмтлийг бууруулах, хорт зуршил, хөдөлгөөний хомсдол, буруу хооллолт/ төлөвшүүлэх мэдээлэл сургалт сурталчилгааг оновчтой арга хэлбэрээр, тасралтгүй зохион байгуулах

4.4.5 Эрэгтэйчүүдийн амьдралын эгзэгтэй мөчүүдэд /0-5 нас, сургуульд орох нас, бэлгийн бойжилт, өсвөр нас, сургууль төгсөх үе, цэргийн нас, насанд хүрэх үе, гэрлэлт, эцэг, өвөө болох, ажилгүй болох, тэтгэвэрт гарах, салалт, бэлэвсрэлт/ тулгарах сэтгэл зүй, бие маш бодийн асуудлуудад зөвлөгөө өгөх арга замыг төрийн болон ТББ, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн хөгжүүлэх

#### 4.4.6 Эрчүүдийн эрүүл мэнд, уламжлалт зан үйлийг өөрчлөх

Хүрэх үр дүн: Эрэгтэйчүүд, хөвгүүдийн дундах эрсдэлт зан үйл буурч, эрүүл зан үйл төлөвших нөхцөл бүрдэж, тусlamж эрэлхийлэх хандлага нэмэгдэнэ.

4.5 Хөтөлбөрийн үйл ажиллагааны тавдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.5.1 Настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөв хооллолт, дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх үйл ажиллагааг дэмжих мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах

4.5.2 Осол, гэмтэл болон архи, тамхины хор уршгийн тухай, архи тамхинаас гарсан сайн туршлагын талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулах

4.5.3 Орон нутагт настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан явуулын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах

4.5.4 Хөгжлийн бэрхшээлтэй өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн тусгай хэрэгцээг хангах нийгэм, хамт олонд түшиглэсэн нөхөн сэргээх нийгэмшүүлэх үйлчилгээг өргөжүүлэх

4.5.5 Настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэдний асран хамгаалагч нарын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг дэмжих, олон нийт, байгууллага, хамт олонд тулгуурласан үйл ажиллагааг дэмжин өргөжүүлэх

4.5.6 Хөгжлийн бэрхшээлтэй төрөх насны эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд болон эмнэлгийн тусlamж үйчилгээ авах боломжийн талаар сургалт зохион байгуулах

4.5.7 Настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, олон эмийн хэрэглээг бууруулах сургалт, сурталчилгааг өргөжүүлэх

4.5.8 Настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх, тэдний эрүүл мэндийг дэмжих олон мэргэжлийн багийн үйл ажиллагааг өргөжүүлэх

Хүрэх үр дүн: Нийгмийн зүгээс настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах эерэг хандлага бэхжиж, настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралын оролцоо сайжирна.

4.6 Хөтөлбөрийн үйл ажиллагааны зургаадугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.6.1 Эрүүл, зөв амьдрах наад захын мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр тогтмол явуулах

4.6.2 Хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгон хэрэглэх талаар иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах

4.6.3 Үйл ажиллагаа явуулж буй хоол, хүнс үйлдвэрлэлийн байгууллага дээр эрүүл мэндийн сөрөг нөлөөтэй /илчлэг өндөртэй, ханасан тос, транс тос, чихэр, давс ихтэй/ хоол хүнсний талаарх нөлөөллийн сургалт, сурталчилгааг зохион байгуулах

4.6.4 Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй зарим бүтээгдэхүүнийг хязгаарласан өдрийг бий болгож, хэрэгжүүлэх

4.6.5 Хүчний байгууллагын ажилтан, албан хаагчдад эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох замаар хуулийн хариуцлага хүлээн ял шийтгэгдсэн иргэний эрүүл мэндийг дэмжих

Хүрэх үр дүн: Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулахад мэргэжлийн байгууллагын ажлын уялдаа, холбоо сайжирна.

Тав. Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт

5.2 Хөтөлбөрийг 2017-2020 он дуустал 4 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ

5.2 Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ

5.2.1 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр (ОНХС, Засаг даргын нөөц хөрөнгө)

5.2.2 Төсөл, хөтөлбөрөөс

5.2.3 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж

Зургаа.Удирдлага, зохион байгуулалт

6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс удирдана.

6.2 Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэд хэрэгжүүлнэ.

6.3 Хөтөлбөрийн зорилго, зорилт тус бүрийг чиглүүлэх мэргэжилтэний бүрэлдэхүүнийг аймгийн Эрүүл мэндийн газар хариуцна.

6.4 Орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах асуудлыг бүх шатны Засаг дарга нар, аймгийн Эрүүл мэндийн газар, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд бусад мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

### Долоо.Хяналт, үнэлгээ

7.1 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс томилогдсон баг хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, зөвлөмж гаргана.

7.2 Үр дүнд суурилсан хяналт үнэлгээ, шинжилгээг хийж ажилдаа хэрэгжүүлэн ажиллана.

#### Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	2016 он Суурь түвшин	2017	2018	2019	2020
			Үр нэлэөний үзүүлэлт			
1	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд	30.0	25.0	22.0	19.0	15.0
2	Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд	101.7	0	0	0	0
3	Жирэмсний эхний 3 сартай хяналтын хувь	83.3	84.0	85.0	86.0	88.0
4	Өсвөр насны охидын төрөлтийн хувь	7.5	7.3	7.0	6.8	6.5
5	Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдвартын түвшин 10 000 хүн амд	107.3	95	90	70	70-с доош
6	Осол гэмтлийн өвчлөл 10 000 хүн амд	88.8	82.7	76.8	70.9	65.1
7	Осол гэмтлийн шалтгаант нас баралт 10 000 хүн амд	8.2	7.5	6.8	6.1	5.5
8	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	76	78	80	83	85
9	Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 10 000 хүн амд	21.6	21.1	19.5	19.0	19-с доош
Үр дүнгийн үзүүлэлт						
9	ЕБСургуулиудад бий болсон эрүүл мэндийн кабинет, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх өрөөний тоо	0	-	2	4	6
10	Эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэгийн хувь	30	40	60	80	100
11	Бэлтгэгдсэн эрүүл мэндийн ажилтан, арга зүйч нарын тоо	0	20	Бүх цэцэрлэгүүдэд		
12	Орон тооны нийгмийн эрүүл мэндийн ажилтнаар хангагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	0	2	4	5	5
13	Эрэгтэйчүүдийн кабинетын тоо	0	1	-	-	-
14	Үе тэнгийн клуб /Эмч клуб/-ын үйл ажиллагаа тогтмолжсон сургуулийн хувь	30.7	42.3	65.3	84.6	100
15	Сайн дурын зөвлөгөө, шинжилгээ өгөх газраар үйлчлүүлсэн хүний тоо	476	900	1500	2000	2500

#### Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин, 2010 оны байдлаар (%, тоо)	Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	
			2015 он	2020 он
1.	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдагсдын хувь	15.0	17.0	22.0
2.	Долоо хоногт 2-3 удаа 30 минутаас доошгүй хугацаагаар дунд зэргийн идэвхтэй хөдөлгөөнийг тогтмол хийдэг хүний эзлэх хувийн жин /биийн	18.0	20.6	25.0
3.	Илүүдэл жинтэй хүний эзлэх хувийн жин /биийн	39.8	38.0	36.0

	жингийн индекс-БЖИ $\geq 25\text{kg/m}^2$ /			
4.	Биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн хувь	15.4	20.0	25.0
5.	Сportoор хичээллэгчдийн хувь	5.0	6.5	8.0

ооо